



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/117НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.03 № 49

танай _____-ны № _____-т

ҮЕНЧ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Б.БУРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын хэмжээнд 157 удаа урлаг, уран бүтээлийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 32,000 иргэд хөдөлмөрчдийг хамруулан ажиллаж, аймгийн Соёл урлагийн байгууллагын хэмжээнд 2025 оны ажил үйлсээрээ дэд байрт шалгарсан, 14 сумдын Соёлын төвийн ажилтны туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, номын санч хүүхдийн зохиолоор 2 драмын жүжиг найруулан үзэгчдэд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг

8426050056
A4-тоот-2026

хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.6 хувийн гүйцэтгэлтэй гэж аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,475,819.40</u>	<u>28,652,797</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,117,287.34	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,117,287.34	-
3121	Төгрөг	26,117,287.34	-
31211	Төрийн сангийн харилцах	24,445,358.40	-
31217	Төрийн сангийн харилцах - орон нутаг	1,671,928.94	-
33	АВЛАГА	767,252.06	-
335	Бусад авлага	767,252.06	-
33510	Байгууллагаас авах авлага	767,252.06	-
35	БАРАА МАТЕРИАЛ	3,591,280	28,652,797
351	Түүхий эд материал	-	20,649,617
35110	Тусгай зориулалттай материал	-	20,649,617
354	Хангамжийн материал	3,591,280	8,003,180
35420	Аж ахуйн материал	-	3,411,900
35470	Бусад хангамжийн материал	3,591,280	4,591,280
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>916,039,034.57</u>	<u>850,134,339.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	916,039,034.57	850,134,339.15
392	Биет хөрөнгө	905,289,034.57	839,759,339.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	909,676,399.81	939,676,399.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(175,550,933.88)	(212,357,989.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	343,268,705	347,988,705
39206	Хуримтлагдсан элэгдэл	(238,665,061.98)	(287,893,317.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,893,827	73,969,710
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,729,535.38)	(31,019,802.76)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	59,534	7,905,634
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,846,100	-
39217	Ном	1,490,000	1,490,000
393	Биет бус хөрөнгө	10,750,000	10,375,000
39301	Програм хангамж	1,686,568	1,686,568
39302	Хуримтлагдсан элэгдэл	(936,568)	(1,311,568)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,000,000	10,000,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>946,514,853.97</u>	<u>878,787,136.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>4,403,066.88</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,403,066.88
413	Өглөг	-	4,403,066.88
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,987,514.88
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,365,552
4136	Бусад өглөг	-	1,050,000
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,050,000
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>946,514,853.97</u>	<u>874,384,069.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	946,514,853.97	874,384,069.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,385,588	45,385,588
51101	Өмч: - төрийн	45,385,588	45,385,588
512	Хуримтлагдсан үр дүн	899,907,766.97	827,776,982.27

51210	Өмнөх үеийн үр дүн	830,344,038.21	867,753,379.71
51220	Тайлант үеийн үр дүн	69,563,728.76	(39,976,397.44)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,221,499	1,221,499
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	946,514,853.97	878,787,136.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	446,731,124	376,724,127
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,181,600	64,412,727
120	Нийтлэг татварын бус орлого	128,181,600	64,412,727
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,531,000	3,117,010
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,881,000	3,117,010
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	125,650,600	40,646,100
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	20,649,617
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	318,549,524	312,311,400
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	208,107,824	203,521,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	208,107,824	203,521,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000	1,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000	1,000,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,241,700	107,790,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,241,700	107,790,400
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	377,167,395.24	400,663,010.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,167,395.24	400,663,010.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,286,395.24	394,695,064.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,684,140.22	170,326,785.68
210101	Үндсэн цалин	94,467,106.49	112,110,589
210102	Нэмэгдэл	41,727,473.73	48,605,148.68
210104	Урамшуулал	13,489,560	9,611,048
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,857,699.67	20,872,653.26
210201	Тэтгэврийн даатгал	13,503,499.67	14,459,134.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,588,300	1,529,649.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	794,300	716,894.91
210204	Ажилгүйдлийн даатгал	794,300	764,824.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,177,300	3,402,149.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,369,224.91	106,142,443.83
210301	Гэрэл, цахилгаан	748,708.91	1,521,927.83
210302	Түлш, халаалт	104,620,516	104,620,516
2104	Хангамж, бараа материалын зардал	6,623,856.42	6,750,900
210401	Бичиг хэрэг	785,600	560,000
210402	Тээвэр, шатахуун	1,000,000	290,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	667,356.42	605,000
210404	Ном, хэвлэл	70,000	-

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,300	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,028,600	5,295,900
2105	Нормативт зардал	210,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,000	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,649,824	55,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,649,824	55,000
2107	Томилолт, зочны зардал	2,331,000	750,000
210702	Дотоод албан томилолт	2,331,000	750,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,860,000	1,820,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,160,000	1,050,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000	620,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,700,650.32	87,977,281.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,434,500	1,082,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,266,150.32	86,895,281.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,881,000	5,967,946.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,881,000	1,270,900
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,101,000	1,270,900
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,697,046.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,634,408.17
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,062,638
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	69,563,728.76	(23,938,883.86)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	16,037,513.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	16,037,513.58
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(16,037,513.58)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	69,563,728.76	(39,976,397.44)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	321,080,524	315,428,410
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,531,000	3,117,010
120	Нийтлэг татварын бус орлого	2,531,000	3,117,010
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,531,000	3,117,010
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,881,000	3,117,010
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	318,549,524	312,311,400
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	208,107,824	203,521,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	208,107,824	203,521,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000	1,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000	1,000,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,241,700	107,790,400

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,241,700	107,790,400
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	309,045,943.13	313,009,310
21	УРСГАЛ ЗАРДАЛ	309,045,943.13	313,009,310
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307,164,943.13	307,041,363.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,831,391.95	168,052,672
210101	Үндсэн цалин	94,614,358.55	100,125,260.41
210102	Нэмэгдэл	41,727,473.40	54,175,016.77
210104	Урамшуулал	13,489,560	13,752,394.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,857,700	21,012,000
210201	Тэтгэврийн даатгал	13,503,200	14,333,400
210202	Тэтгэмжийн даатгал	1,588,600	1,669,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	794,300	834,800
210204	Ажилгүйдлийн даатгал	794,300	834,800
210205	Эрүүл мэндийн даатгал	3,177,300	3,339,300
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,369,771.06	106,156,891.83
210301	Гэрэл, цахилгаан	889,149.79	1,521,927.83
210302	Түлш, халаалт	106,480,621.27	104,634,964
2104	Хангамж, бараа материалын зардал	4,267,356.42	1,695,200
210401	Бичиг хэрэг	600,000	300,000
210402	Тээвэр, шатахуун	1,000,000	290,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	667,356.42	855,000
210404	Ном, хэвлэл	1,000,000	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000	250,200
2105	Нормативт зардал	500,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,135,823.70	1,969,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,935,823.70	1,969,200
210604	Урсгал засвар	1,200,000	-
2107	Томилолт, зочны зардал	2,331,000	750,000
210702	Дотоод албан томилолт	2,331,000	750,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,871,900	2,650,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,401,900	2,500,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000	4,755,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000	4,755,400
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,881,000	5,967,946.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,881,000	1,270,900
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,101,000	1,270,900
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,697,046.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,634,408.17
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,062,638
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,034,580.87	2,419,100

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,420,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,420,000
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,420,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,420,000
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(2,420,000)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,034,580.87	(900)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,082,706.47	26,117,287.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,117,287.34	26,116,387.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	45,385,588	1,221,499	830,344,038.21	876,951,125.21
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,385,588	1,221,499	830,344,038.21	876,951,125.21
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	69,563,728.76	69,563,728.76
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,385,588	1,221,499	899,907,766.97	946,514,853.97
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	45,385,588	1,221,499	899,907,766.97	946,514,853.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(32,154,387.26)	(32,154,387.26)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,385,588	1,221,499	867,753,379.71	914,360,466.71
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(39,976,397.44)	(39,976,397.44)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,385,588	1,221,499	827,776,982.27	874,384,069.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	319,354,600	310,732,263.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	319,354,600	310,732,263.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,083,700	309,461,363.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,002,700	168,052,672
210101	Үндсэн цалин	98,939,400	100,125,260.41
210102	Нэмэгдэл	54,416,800	54,175,016.77
210104	Урамшуулал	10,646,500	13,752,394.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,500,300	21,012,000
210201	Тэтгэврийн даатгал	14,030,600	14,333,400
210202	Тэтгэмжийн даатгал	1,617,400	1,669,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	808,700	834,800

210204	Ажилгүйдлийн даатгал	808,700	834,800
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,900	3,339,300
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,191,300	106,156,891.83
210301	Гэрэл, цахилгаан	2,645,500	1,521,927.83
210302	Түлш, халаалт	103,345,800	104,634,964
210303	Цэвэр, бохир ус	200,000	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,810,200	1,695,200
210401	Бичиг хэрэг	360,000	300,000
210402	Тээвэр, шатахуун	300,000	290,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000	855,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200	250,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,378,400	4,389,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,778,400	4,389,200
210604	Урсгал засвар	1,600,000	-
2107	Томилолт, зочны зардал	750,000	750,000
210702	Дотоод албан томилолт	750,000	750,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,650,000	2,650,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,500,000	2,500,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	150,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,800,800	4,755,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,800,800	4,755,400
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,270,900	1,270,900
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,270,900	1,270,900
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,270,900	1,270,900
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	26,117,287.34
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26,116,387.34
610001	Төсвийн байгууллага	1	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.5	6.5
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	3.5	3.5
620003	Үйлчлэх ажилтан	2	2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6.5	6.5
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.5	2.5

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 138,515.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 132,298.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Соёлын төвийн барилгын дотор хананд дуу тусгаарлагчийг 30,000.0 мянган төгрөгөөр хөрөнгөд сайжруулалт хийгээгүй, үндсэн хөрөнгө данснаас 18,466.0 мянган төгрөгийн урлагийн хувцас, хэрэгслийг бараа материал данс руу шилжүүлэн бүртгээгүй,
- Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд 2024 оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлтэйгээр тайлагнаж, 26,117.3 мянган төгрөгөөр татан төвлөрүүлснээр тусгасан,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийг зардлыг 1,827.9 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
- Санхүүгийн программд 2022 онд ашиглалтад орсон үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс 6,038.0 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүйгээс орхигдуулсан,
- Цалингийн ашиг, хувь хүмүүстэй холбоотой тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс 1,946.0 мянган төгрөгийн өр төлбөрийг дутуу тусгасан,
- Тайлант онд 4,411.9 мянган төгрөгөөр худалдан авсан БҮТЭЗ-ийг зарцуулснаар хасаж бараа материалын үлдэгдэл зөрүүтэй,
- Тайлант үеийн үр дүн 43,491.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 6,216.9 мянган төгрөгийн 3 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,216.9 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 6,216.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Цалин, орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ЗДТГ-т сан хариуцсан нягтлан бодогч нь Соёлын төвд нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг, орон нутагт ажилласны нэмэгдлийг ажил хавсран гүйцэтгэсэн албан тушаалтанд давхардуулан 6,216,902 төгрөгийг бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар “Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтооо

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн данс бүртгэлд байгаа 2011 онд ашиглалтад орсон суурь компьютерүүд, asolous санхүүгийн программын ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэн ажиллах,

3.2.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, сар бүрийн төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбар, 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн дагуу 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 8-ны өдрийн дотор", 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 16-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасан заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээг бүрэн мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үенч сумын Соёлын төв	7	132,298.2	4	39,811.9	3	92,486.3	7	132,298.2	-	-	-	-
Дүн	7	132,298.2	4	39,811.9	3	92,486.3	7	132,298				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үенч сумын Соёлын төв	2	6,216.9	1	6,216.9			1		-	-	-	-
Дүн	2	6,216.9	1	6,216.9	-	-	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Үенч сумын Соёлын төв	1	0.0							1	
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	

ТАВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-